



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



Сүхбаатар аймгийн нийгэм,
эдийн засгийн байдал
2022/12

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2022/12



sukhbaatar.nso.mn

www.nso.mn

www.1212.mn



Хэрэглэгч та Статистикийн
тоон мэдээллийн 1212.mn
аппликейшнаар авна уу.



Хэрэглэгч та өөрийн гар
утаснаас QR code уншуулагч
аппликейшни ашиглан тухай
сарын мэдээллийг авч үзэх.
/интернетэд холбогдсон байх/



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

12 сар
2022

Баруун-Урт сум



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	3
Аргачлалын тайлбар	4-5
Товч танилцуулга	6-21
Үндсэн үзүүлэлтүүд	22

I. Нийгмийн үзүүлэлт

I.1 Хүн ам	23-28
I.2 Хөдөлмөр	28-30
I.3 Нийгмийн даатгал, нийгмийн халамж	31-32
I.4 Боловсрол	33-39
I.5 Эрүүл мэнд	40-41
I.6 Соёл, урлаг	42
I.7 Газар өмчлөл	43
I.8 Гэмт хэрэг	44-45

II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Мөнгө, банк, даатгал	46
II.2 Төрийн санхүү	47-49
II.3 Төсөл хөтөлбөр	50
II.4 Үнэ	51-52
II.5. Статистикийн бизнес регистрийн сан	53-55
II.6 Хөдөө аж ахуй	56-74
II.7 Аж үйлдвэр	75-78
II.8 Тээвэр	79
II.9 Барилга	80



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал:

Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

Төл гэсэн нь төлөвлөгөө, Гүйц гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI, VII, VIII, IX, X, XI, XII)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-VII, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

...	Мэдээлэл байхгүй	%	Хувь
0.0	Маш бага тоо	¹	Дахин
-	Гүйцэтгэл байхгүй	мянга	1000
x	Бүтцийн өөрчлөлт	сая	10 ⁶
+, -	Зөрүү	тэрбум	10 ⁹
*	Урьдчилсан гүйцэтгэл	их наяд	10 ¹²

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. 22-21 нь 2022 оны үзүүлэлт тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд:** Уг салбарын мэдээг холбогдох газраас нь авч, нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээг холбогдох газраас нь авч, нэгтгэн гаргаж ирүүлдэг.

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

- Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.
- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
- Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.



- 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.
Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2020 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкнуудаас мэдээг авч нэгтгэн, банкнуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлого болон татварын, татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ. Төсвийн мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй: Мал аж ахуй:** Жилийн эцсийн мал тооллогын мэдээллийн үр дүнгээс тооцон гаргадаг.
 - **Газар тариалан:** Газар тариалангийн эцсийн мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулах ба аж ахуй нэгж байгууллагууд сумын тамгын газарт салбар хариуцсан ажилтанд өгч нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа Нэгдсэн үндэсний байгууллагын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.
 - **Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо:** гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.
 - **Борлуулсан бүтээгдэхүүн** нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.
 - **Гол нэр төрлийн** бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Өрх, Хүн ам

Оны эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 19.1 мянган өрх, 65.9 мянган хүн амтай болж урьд оноос 329 өрхөөр, хүн ам 684 хүнээр тус тус өслөө. Нийт өрхийн 9.7 мянга (50.5%), хүн амын 33.1 мянга (50.2%) нь хөдөөд амьдарч байна.


Хүн амын 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амыг насны ангиллаар авч үзвэл 0-14 насны хүн ам 21.5 мянга (32.6%), 15-34 насны хүн ам 18.9 мянга (28.8%), 35-59 насны хүн ам 20.1 мянга (30.5%), 60 ба дээш насны хүн ам 5.3 мянга (8.1%) болж, хүн ам зүйн ачаалал 60.0 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд хамгийн их өрх, хүн амтай Баруун-Урт сумын 1-р баг 1140 өрх, 3977 хүнээр 67 баг дотор тэргүүлж байгаа бол хамгийн бага өрх, хүн амтай нь Халзан сумын 2-р баг 93 өрх, 248 хүнтэй байгаа юм.


Зураг I.1.1 Хүн ам, өрхийн тоо, жил бүрийн эцсийн байдлаар



Зураг I.1.2 Хүн амын нас, хүйсний суварга



Зураг I.1.3 Хүн амын тоо, насны бүлгээр





Улсын бүртгэлийн хэлтэст энэ онд шинээр төрсөн хүүхэд 1279, нас барсан хүн 317, гэрлэлт 237, цуцлалт 44 тус тус бүртгүүлсэн. Сүхбаатар аймагт нийслэл, өөр аймгуудаас 350 иргэн шилжин иржээ.

Аймгийн хэмжээнд 2022 онд 750 өнчин хүүхэд байгаагийн 30 (4.0%) нь бүтэн өнчин хүүхэд, 720 (96.0%) нь хагас өнчин хүүхэд байна. Нийт өнчин хүүхдийн 60 (8.0%) нь 0-4 насны, 183 (24.4%) нь 5-9 насны, 313 (41.7%) нь 10-14 насны, 194 (25.9%) нь 15-аас дээш насны хүүхэд байна.

2022 онд өмнөх оноос бүтэн өнчин хүүхдийн тоо 7, хагас өнчин хүүхдийн тоо 19-өөр тус тус нэмэгджээ.

2022 оны эцэст өрх толгойлсон эх 2.2 мянга болж, өмнөх оноос 19 (0.8%)-өөр, өрх толгойлсон эцэг 0.5 мянга болж, өмнөх оноос 33 (6.4%)-аар тус тус буурчээ. Өрх толгойлсон эх /эцэг/-үүдийн 1.8 мянга (66.5%) нь 3 хүртэлх, 0.8 мянга (29.0%) нь 3-5, 0.1 мянга (4.5%) нь 6, түүнээс дээш гишүүнтэй өрхийг толгойлж байгаа бөгөөд 1.9 мянга (69.4%) нь сумын төв болон хөдөөд амьдарч байна.


Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 2022 оны жилийн эцэст 3.1 мянга болж, өмнөх оноос 374 (13.8%)-өөр өссөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1.0 мянга (33.8%) нь төрөлхийн, 2.0 мянга (66.2%) нь олдмол, төрлөөр авч үзвэл 435 (14.1%) нь хараа, 616 (20.0%) нь хөдөлгөөн, 99 (3.2%) нь хавсарсан, 83 (2.7%) нь яриа, 548 (17.8%) нь сэтгэц, 247 (8.0%) нь сонсгол, 1053 (34.2%) нь бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр Сүхбаатар аймгийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар 1112 эх амаржиж, 1110 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оноос амаржсан эх 253 (18.5%)-аар, амьд төрсөн хүүхдийн тоо 266 (19.3%)-ээр тус тус буурчээ.

2022 оны жилийн эцсийн байдлаар нас баралт 294 болж, өмнөх оноос 86 (22.6%)-аар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 17.0, нас баралт 4.5 байна.

Зураг.I.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо






I.2 Хөдөлмөр

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2022 оны жилийн эцэст 412 болсны 185 (44.9%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 363 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 200 (35.5%) хүнээр буурсан байна.

Жилийн эцсийн байдлаар хөдөлмөр халамж үйлчилгээний газарт 2390 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 761 (31.8%) иргэн ажилд зуучлагдан оржээ.

Зураг.I.2. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд



Ажилгүй иргэдийн 297 (81.8%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 64 (17.6%) нь бакалавр, 9 (2.5%) нь тусгай дунд, 16 (4.4%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 200 (55.1%) нь бүрэн дунд, 53 (14.6%) нь суурь, 15 (4.1%) нь бага боловсролтой, 6 (1.7%) боловсролгүй хүмүүс байна.

Зураг.I.3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр



2022 оны жилийн эцсийн байдлаар 648 шинэ ажлын байр бий болсны дотор хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барил, ан агнуурын салбар 231 (28.5%), боловсруулах үйлдвэр 120 (18.5%), уул уурхайн салбар 197 (30.4%) байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.



Шинэ ажлын байранд ажиллаж буй иргэдийн 541 (83.5%) байнга, 89 (13.7%) түр, 18 (2.8%) улирлын чанартай ажлын байранд зуулчлагдан оржээ.



I.3 Нийгмийн даатгал, халамж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн нийт орлого 2022 оны жилийн эцэст 21.1 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 2.9 (16.1%) тэрбум төгрөгөөр өсчээ. Үүнээс ажил олгогчоос 19.2 тэрбум төгрөгийн шимтгэл төлсөн нь өмнөх оноос 2.6 (15.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аймгийн хэмжээнд сайн дурын даатгуулагчид 1.6 тэрбум төгрөгийн шимтгэл төлж, өмнөх онтой харьцуулахад 0.3 (25.1%) тэрбум төгрөгөөр өсчээ.

2022 оны жилийн эцэст нийгмийн даатгалын сангаас нийт 9.6 мянган иргэнд 58.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос, 7.4 мянган өндөр настанд 44.4 тэрбум төгрөг, 1.4 мянган хөдөлгөөний бэрхшээлтэй иргэнд 8.4 тэрбум төгрөг, 0.4 мянган тэжээгчээ алдсан иргэнд 1.9 тэрбум төгрөг, 0.3 мянган иргэнд цэргийн тэтгэвэрт 3.5 тэрбум төгрөг, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчтөний даатгалаас 0.02 мянган иргэнд 0.1 тэрбум төгрөгийг тус тус бүрэн олгосон байна.

Нийт тэтгэвэр авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 425 (4.6%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 17.1 (41.7%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2022 оны эцэст 27.6 мянган иргэнд 11.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, тусламж, дэмжлэгийг олгосон байна. Үүнийг төрлөөр нь авч үзвэл: Улсын төсвөөс нийгмийн халамжийн тэтгэврийг 1.3 мянган иргэнд 4.4 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 2.3 мянган иргэнд 2.0 тэрбум төгрөг, бусад хөнгөлөлт, тусламж, дэмжлэгт 17.5 мянган иргэнд 2.1 тэрбум төгрөгийг, орон нутгийн төсвөөс 1.1 мянган иргэнд 0.9 тэрбум төгрөгийг, цахим системээр эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг 6.1 мянган иргэнд 2.3 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.



I.4 Боловсрол

Аймгийн хэмжээнд 2022/2023 оны хичээлийн жилийн эхний байдлаар 24 цэцэрлэг (СӨБ), 16 ерөнхий боловсролын сургууль (ЕБС), 1 техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий боловсролын сургуульд 2022-2023 оны хичээлийн жилд 13.8 мянган суралцагчид байгаагийн 6.9 (50.0%) мянга нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс суралцагчдын тоо 388 (2.9%) хүүхдээр өсчээ.

Нийт суралцагчдын 7.2 (51.9%) мянга нь 1-5-р ангид, 4.8 (34.8%) мянга нь 6-9-р ангид, 1.8 (13.3%) мянга нь 10-12-р ангид суралцаж байна.

2022/2023 оны хичээлийн жилд 1-р ангид 1.4 мянган суралцагчид элсэн орсны 715 (49.4%) эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 42 (5.5%)-оор



буурсан байна. Мөн 12-р ангид 542 суралцагчид байгаагийн 307 (56.6%) нь эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 48 (8.1%)-аар буурсан байна.

Зураг I.4.1 Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо



Энэ хичээлийн жилд 457 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 30.2 суралцагч ногдож байна. 1 багшид ногдох суралцагчийн тоо 21 байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.


2022/2023 оны хичээлийн жилд ЕБС-д 1136 ажиллагсад байгаагийн 644 (56.7%) үндсэн багш бөгөөд үүний 528 (81.9%) нь эмэгтэй багш нар байна. Өмнөх оны мөн үеэс багшийн тоо 4 (0.6%)-өөр өссөн байна.

Дотуур байранд 970 сурагч амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 101 (11.6%) сурагчаар өсчээ.

Ерөнхий боловсролын сургуулийг 2021-2022 оны хичээлийн жилд 2972 сурагчид өдрөөр төгсжээ. Үүнээс: бага боловсролыг 1439 (48.4%), суурь боловсролыг 943 (31.7%), бүрэн дунд боловсролыг 590 (19.9%) сурагчид тус тус эзэмшжээ. Өнгөрсөн оны мөн үеэс нийт төгсөгчдийн тоо 187 (6.7%) суралцагчдаар өссөн байна.

Нийт төгсөгчдийн 1528 (50.4%) эмэгтэй сурагчид байна.

Зураг I.4.2 Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн тоо






Сургуулийн өмнөх боловсрол: 2022-2023 оны хичээлийн жилд 163 бүлэгт 5.6 мянган хүүхэд хүмүүжиж байгаагийн 2.7 (48.1%) мянга нь эмэгтэй хүүхэд байна. Өмнөх оны мөн үеэс 1.6 мянган (38.5%) хүүхдээр өсчээ. Нийт хүмүүжиж байгаа хүүхдийн 4.6 (81.5%) мянга нь үндсэн цэцэрлэгт, 1.0 (18.5%) мянга нь хувилбарт сургалтад хамрагдсан байна.

2022-2023 оны хичээлийн жилд СӨБ-д 618 ажиллагсад байгаагийн 182 (29.4%) нь үндсэн багш, 149 (24.1%) нь туслах багш байна. Өмнөх оны мөн үетэй үндсэн багш ижил түвшинд байгаа бол туслах багш 1 (0.7%-ээр буурчээ. Нийт үндсэн багш нарын 8 (4.6%), туслах багш нарын 3 (2.1%) нь эрэгтэй багш байна.

Зураг 1.4.2 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Сүхбаатар аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2022-2023 оны хичээлийн жилд 15 мэргэжлээр 387 суралцагчид суралцаж байгаагийн 149 (38.5%) нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс нийт суралцагчдын тоо 69 (15.1%) суралцагчаар буурсан байна.

Нийт суралцагчдын 90 (23.3%) мэргэжлийн боловсрол эзэмшихээр 1 жилийн хугацаатай суралцаж байна.

Нийт суралцагчдын 55 (14.2%) барилгын засал чимэглэгч, 52 (13.4%) авто машины засварчин, 36 (9.3%) гоо засалч, 33 (8.5%) гар урлалын ажилтан, 30 (7.8%) төмөр замын барилгачин, 25 (7.2%) оёмол бүтээгдэхүүний оёдолчин, 25 (7.2%) бетон арматурчин гэх мэт мэргэжлээр сурч байгаа нь олонх байна.

Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг 2021-2022 оны хичээлийн жилд 9 мэргэжлээр 272 хүүхэд төгссөний 95 (35.0%) эмэгтэй хүүхэд байна. Нийт төгсөгчдийн 151 (55.5%) мэргэжлийн боловсролыг 1 жилийн хугацаатай, 121 (44.5%) 2.5 жилийн хугацаатай мэргэжлийн боловсролыг эзэмшжээ. Өмнөх оны мөн үеэс төгсөгчдийн тоо 86 (46.2%) суралцагчдаар өсчээ. Нийт төгсөгчдийн 134 (49.3%) суралцагчид ажлын байртай болсон байна.



Зураг I.4.5 Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчдийн тоо



I.5 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2022 онд 265.5 мянган хүнд үзлэг хийсэн нь урьд оны мөн үеэс 69.8 (35.7%) мянган хүнээр өсч, 15.3 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 72.5 мянган хүн хамрагдсан нь урьд оны мөн үеэс 10.2 (16.4%) мянган хүнээр өссөн.

Түргэн тусламжийн дуудлага 17.9 мянган удаа гарсны 3.1 (17.3%) мянга нь алсын дуудлага байгаа нь урьд оны мөн үеэс 0.6 (16.2%) мянган удаагийн дуудлагаар буурсан байна.


Жилийн эцсээр 5.4 мянган халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 9.1 мянга (63.0%) тохиолдлоор буурахад коронавирус /ковид-19/ халдвар 9.3 мянгаар буурсан нь голлон нөлөөлсөн байна.




I.6 Соёл, урлаг:

Хөгжимд жүжгийн театр: Танхимаар 10.9 мянган үзэгчдэд 31 удаа тоглолтоор үйлчилж, 27.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс тоглолтын тоо 22 (3.4 дахин), орлогын хэмжээ 22.2 сая (4.3 дахин) төгрөгөөр тус тус өссөн байна. 2022 оны жилийн эцэст танхимын үзэгчдийн тоо 0.7 мянга (6.0%)-аар буурч, цахим тоглолт хийгдээгүй.

Зураг I.5.1 Нийт тоглолтын тоо




Зураг I.5.2 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн






Музей: 2022 оны жилийн эцэст 23.4 мянган хүнд 2.3 мянган үзмэрээр үйлчилж, 2.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх онтой харьцуулахад үзэгчдийн тоо 20.2 мянган (7.3 дахин) хүнээр, үзмэрийн тоо 46 (2.0%)-ээр тус тус өсч, орлого 0.1 сая (3.4%) төгрөгөөр буурчээ.

Зураг I.5.3 Нийт үзмэрийн тоо




Зураг I.5.4 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн




Номын сан: Нийт 49.9 мянган номоор 20.1 мянган уншигчдад үйлчилжээ. Өмнөх оны мөн үеэс номын тоо 0.7 (1.4%) мянгаар, уншигчдын тоо 15.0 мянган (3.9 дахин) хүнээр тус тус өсчээ.

Зураг I.5.5 Нийт номын тоо




Зураг I.5.6 Нийт уншигчдын тоо, мян.хүн




I.6 Газар өмчлөл:

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 12.2 мянган иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 11.3 мянган иргэнд 1023.9 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байна.

Зураг I.6.1 Газар өмчлөх өргөдөл гаргасан иргэдийн тоо



Зураг I.6.2 Засаг даргын шийдвэр гарсан иргэдийн тоо





I.7 Гэмт хэрэг

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 онд 511 болж, өмнөх оноос 167 (48.5%)-оор өсчээ. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 126 (73.2%), хүний эрүүл мэнд халдашгүй байдлын гэмт хэрэг 21 (19.3%)-ээр өссөн нь голлон нөлөөлжээ.


Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 15 хүн нас барж, 159 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 12.4 тэрбум төгрөгийн хохирол учирсны 7.6 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 409 хүн холбогдон сэжиглэгдсэний 136 (33.3%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт сэжигтэн, яллагчдын 90 (22.0%) нь урьд нь ял шийтгэгдсэн байна.

Нийт 442 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 9 (2.1%) хүнээр өссөн байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 246 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 56.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр өссөн байна.

Зураг.I.7.1 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, банк:

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 191.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 0.9 (0.5%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 11.6 (6.4%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 133.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 4.0 (3.1%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 5.4 (4.8%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 12 дугаар сарын эцэст 1.3 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.7 хувийг эзэлж байна.



Зураг.II.1. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, тэрбум.төг



Даатгал: Орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 852.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 333.8 (64.3%) сая төгрөгөөр өссөн байна.

Нөхөн төлбөр 738 хүнд 148.6 сая төгрөг олгосны дотор авто тээврийн хэрэгсэлд 16.6 сая, жолоочийн хариуцлагад 60.2 сая, иргэдийн эд хөрөнгөнд 1.9 сая, гэнэтийн осолд 18.6 сая, аж ахуй нэгжийн хөрөнгө 0.5 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 22.8 сая, зээлийн эрсдэлийн даатгалд 4.2 сая төгрөгийг тус тус олгожээ.

Зураг.II.1.2 Даатгалын төрлөөр



II.2 Төрийн санхүү:

Аймгийн төсвийн нийт орлого 2022 оны жилийн эцсийн байдлаар 62.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 15.6 (19.9%) тэрбум төгрөгөөр, төсвийн




зарлага санхүүжилт 52.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.9 (22.3%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Орон нутгийн төсөвт 26.3 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 12.8 (94.3%) тэрбум төгрөгөөр өссөн гүйцэтгэлтэй гарчээ.

Жилийн эцсийн байдлаар Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 6.7 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 2.2 (25.0%) тэрбум төгрөгөөр буурч, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 12.1 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 4.6 (27.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зураг. II.2. Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг



Жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хөрөнгө оруулалт 32.8 тэрбум төгрөг болж өмнөх оноосоо 24.7 тэрбум төгрөг буюу 4.0 дахин өссөн байна.



II.3 Төсөл хөтөлбөр: Аймгийн хэмжээнд олгосон төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлаар авч үзвэл: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хэмжээнд 20 иргэнд 120.0 сая, нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөрийн хэмжээнд 16 төслийн хүрээнд 156 иргэнд 55.7 сая, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 24 иргэнд 100.0 сая, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 35 иргэнд 300.0 сая, мод тарих арга хэмжээнд 334 иргэнд 126.7 сая, малжуулах төсөл хөтөлбөрийн хэмжээнд 70 өрхөд 350.0 сая, залуучуудын гарааны бизнес санхүүгийн дэмжлэг төсөлд 10.0 сая нийт 1.1 тэрбум төгрөгийн төсөл санхүүжилтийг тус тус олгоод байна.




II.4 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2022 оны 12 дугаар сард өмнөх сараас 0.6 хувь, өмнөх оны мөн үеэс 12.7 хувиар тус тус өссөн.



Зураг. II.4.1 Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Ерөнхий индекс жилийн эцсээс 12.7 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 21.4 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 5.3 хувь, хувцас бөс барааны бүлгийн үнэ 12.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 4.8 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 20.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 10.5 хувь, тээврийн бүлгийн үнэ 10.6 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ 9.0 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 17.0 хувь, бусад бараа, үйлчилгээ 20.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт. II.4.1 Хэрэглээний үнийн индекс, бүлгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2022.XII}{2020.XII}$	$\frac{2022.XII}{2021.XII}$	$\frac{2022.XII}{2022.XI}$
Ерөнхий индекс	131.0	112.7	100.6
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	146.7	121.4	101.6
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	111.1	105.3	100.1
Хувцас, бөс бараа, гутал	127.9	112.0	100.5
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	139.9	104.8	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	137.0	120.6	100.1
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	119.3	110.5	100.0
Тээвэр	136.5	110.2	101.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.5	100.6	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	116.1	109.0	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	137.9	117.0	100.0
Даатгал санхүүгийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	132.9	120.3	101.4



II.5 Статистикийн бизнес регистрийн сан

Статистикийн бизнес регистрийн санд 2022 оны эцэст 1381 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 732 (53.0%) нь үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо өмнөх оны мөн үеэс 37 (4.8%) аж ахуй нэгжээр буурчээ.

Бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хариуцлагын хэлбэрээр авч үзвэл ХХК нь 424 (57.9%), төсөвт байгууллага 132 (18.0%), төрийн бус байгууллага тус бүр 68 (9.3%), хоршоо, нөхөрлөл 84 (11.5%) байна.

Эдийн засгийн салбарын ангиллаар нь авч үзвэл бөөний болон жижиглэн худалдаа гэр ахуйн барааны үйлчилгээнд 435 (59.4%), Үйлчилгээний бусад үйл ажиллагаанд 229 (31.3%), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа болон боловсруулах салбарын үйл ажиллагаанд 93 (12.7%), Хөдөө аж ахуйн, ан агнуур, ойн аж ахуйн салбарт 123 (16.8%), байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаанд 68 (9.2%), боловсролын салбарын үйл ажиллагаанд 55 (7.5%), төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын үйл ажиллагаанд 49 (6.7%) байгаа нь бусад салбарын аж ахуйн нэгж, байгууллагаас олон байна.



II.5 Хөдөө аж ахуй

Малтай болон малчин өрх, малчид: Энэ онд 11.4 мянган өрх, 62 аж ахуй нэгж, байгууллагад нийтдээ 4.6 сая толгой мал тоолууллаа. Нийт малтай өрхийн дотор мал бүхий 2.4 мянган өрх, малчин 8.9 мянган өрх, тавиул малтай 82 өрх байна. Мал аж ахуйн салбарт 15.9 мянган малчид ажиллаж байна.

Нийт малтай өрхийн 40.9 хувийг 200 хүртэлх, 29.8 хувийг 201-500 хүртэлх малтай өрх, 29.3 хувийг 501 дээш малтай өрх эзэлж байгаа нь 200 хүртэлх малтай өрх урьд оноос 2.3 пунктээр буурч, 201-500 хүртэлх малтай өрхийн тоо урьд оноос 0,7 пунктээр буурч 501 дээш малтай өрх 3 пунктээр өссөн байна. Энэ онд 1110 өрх мянгаас дээш мал тоолуулсан бөгөөд шинээр 191 өрх мянгаас дээш мал тоолуулжээ.

Мал аж ахуй: Мал сүрэг урьд оноос 441.9 (10.5%) мянган толгойгоор өсч, 4.6 сая толгой малд хүрсний дотор тэмээ 8 мянга, адуу 402.5 мянга, үхэр 341.8 мянга, хонь 2.4 сая, ямаа 1.5 сая толгой болжээ.

Нийт мал сүрэгт хонь 51,9 хувь, ямаа 31.9 хувь, адуу 8,7 хувь, үхэр 8,1 хувь, тэмээ 0.2 хувийг эзэлж байна.

Аймгийн дүнгээр 5 төрөл дээр мал өссөн байна. Сумдаар авч үзвэл Баруун-Урт, Баяндэлгэр, Дарьганга, Наран, Онгон, Уулбаян, Сүхбаатар, Түвшинширээ,




Түмэнцогт, Халзан сумд 5 төрөл дээр, Асгат, Мөнххаан, Эрдэнэцагаан сумд 4 төрөл дээр малаа өсгөжээ.

Манай аймаг улсын хэмжээнд нийт малаараа 5-рт, тэмээгээр 10-рт, адуугаар 3-рт, үхрээр 6-рт, хониор 5-рт, ямаагаар 11-рт байранд тус тус орж байна.

Аймгийн хэмжээнд 565.8 мянган толгой малаараа Баяндэлгэр сум аймагтаа тэргүүлж байна. Төрлөөр авч үзвэл 307.7 мянган хонь, 198.6 мянган ямаагаар Баяндэлгэр сум, 1.3 мянган тэмээгээр Түвшинширээ сум, 56.1 мянган адуугаар Эрдэнэцагаан сум, 46.2 мянган үхрээр Баруун-Урт сумд аймагтаа тэргүүллээ.

Зураг II.6.1 Малын тоо, мянган толгой, жил бүр эцсийн байдлаар



Улсад 330 сум дотор нийт малаар Баяндэлгэр сум 2-рт, Баруун-Урт сум 4-рт адуугаар Эрдэнэцагаан сум 1-рт, Баруун-Урт сум 2-рт, Сүхбаатар сум 4-рт, хониор Баяндэлгэр сум 3-рт, ямаагаар Баяндэлгэр сум 4-рт орж байна.

Хээлтэгч мал 2.1 сая толгой тоологдсон нь нийт малын 44 хувийг эзэлж байна.

2022 оны жилийн эцэст оны эхний эх малын 83.6 хувь буюу 1.5 сая эх мал төллөж, гарсан төлийн 99.1 хувь буюу 1.5 сая төл бойжуулж авчээ.

Оны эхний малын 0.4 хувь болох 15.8 мянган том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 27.6 (64.0%) мянган толгой малаар буурсан байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 39, адуу 1.7 мянга, үхэр 1.7 мянга, хонь 6.1 мянга, ямаа 6.3 мянган толгой байна.

Зүй бусаар хорогдсон том малын 1.5 хувь болох 242 толгой мал өвчнөөр хорогдсон нь өмнөх оноос буурсан байна.



Газар тариалан: 2022 онд үр тариа 4.1 мянган га-д, төмс 75.7 га-д, хүнсний ногоо 50.1 га-д, тэжээлийн ургамал 0.8 мянган га-д, техникийн ургамал 2.1 мянган га-д тариалж, 3.5 мянган тн үр тариа, 585.9 тн төмс, 872.2 тн хүнсний ногоо, 0.8 мянган тн техникийн ургамал, 1.8 мянган тн



тэжээлийн ургамал хурааж авсан нь урьд оноос хүнсний ногоо 2.3 дахин, техникийн ургамал 14.2 хувиар тус тус өсч, үр тариа 29 хувиар, төмс 26.9 хувиар, тэжээлийн ургамал 56.8 хувиар буурчээ.

Зураг II.6.2 Тариалсан талбай Зураг
га-р, 2022 он



II.6.3 Ургац хураалт, хадлан
тэжээл, тн-оор, 2022 он



Оны эцэст бэлтгэсэн өвс 18.1 мянган тн, хужир шүү 8.8 мянган тн, гар тэжээл 197.4 тн тус тус бэлтгэсэн нь өмнөх оноос гар тэжээл 13.1 хувиар, хужир шүү 43.5 хувиар өсч, бэлтгэсэн өвс 17.6 хувиар буурсан байна.



II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 51.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 5.7 (10.1%) тэрбум төгрөгөөр буурчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 7.6 (16.0%) тэрбум төгрөгөөр буурч, боловсруулах аж үйлдвэрийнх 1.8 (37.5%) тэрбум төгрөг, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл 0.3 (6.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Оны үнээр 352.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 124.0 (54.3%) тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс цайрын баяжмал, хайлуур жонш, дулаан, цахилгаан, бууз, банш, бялуу, талх, хэрчсэн гурил, адуу, үхэр, хонь, ямааны мах, монгол дээл, тэрлэг, дээлнээс бусад монгол хувцас, гутал, өмд, гэрийн бүрээс туурга бусад хэрэгсэл, гэрийн бусад модон тавилга, модон сандал, бетон зуурмаг, эсгий, сувагжуулалт зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс өссөн байна.



II.8 Тээвэр

Авто тээвэр бүхий байгууллагууд энэ онд 166.4 мянган тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 22.4 (11.9%) -оор буурчээ.

Мөн давхардсан тоогоор 16.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс зорчигчдын тоо 11.7 (3.6 дахин) мянган хүнээр өсчээ.


Тээврийн хэрэгслийн тооллогын дүнгээр 10.5 мянган тээврийн хэрэгсэл үзлэг тооллогод хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 0.7 (7.9%) мянгаар буурсан байна. Тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл: 10.1 (95.9%) мянган автомашин, 0.1 (1.3%) мянган мотоцикл, 0.3 (2.5%) мянган чиргүүл, 0.03 (0.3%) мянган механизм байна.



II.6 Барилга

Барилгын байгууллагууд 2022 онд нийт 21.8 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 6.6 (30.5%) тэрбум төгрөг нь аймгийн барилгын байгууллага, 15.2 (69.5%) тэрбум төгрөг нь гадны барилгын байгууллагууд хийж гүйцэтгэсэн байна.

Зураг.II.4. Барилга угсралт, их засварын ажил, сая.төг



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эцсийн байдлаар

	Хэмжих нэгж	2020	2021	2022	Зөрүү	$\frac{2022}{2021}$ %
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд						
Өрхийн тоо	өрх	18 294	18 820	19 149	329	101.7
Суурин хүн ам	хүн	64 218	65 228	65 912	684	101.0
Төрсөн хүүхэд /улсын бүртгэлийн мэдээ/	хүн	1 590	1 485	1 279	- 206	86.1
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	462	563	363	- 200	64.5
Суралцагчид, бүгд	хүүхэд	12 866	13 395	13 783	388	102.9
үүнээс: 1-р ангид суралцагчид	хүүхэд	1 489	1 518	1 447	- 71	95.3
Төгсөгчид, бүгд	хүүхэд	2 627	2 785	2 972	187	106.7
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	509	14 443	5 369	-9 074	37.2
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	408	344	511	167	148.5
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	102.9	111.6	112.7	1.1	-
Иргэдийн хадгаламж	тэрбум.төг	132.9	139.3	133.9	- 5.4	96.1
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум.төг	134.5	180.0	191.6	11.6	106.4
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум.төг	72.0	78.5	62.9	- 15.6	80.1
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум.төг	71.4	74.3	52.0	- 22.3	70.0
Малтай өрх	өрх	10 782	11 136	11 453	317	102.8
Малчин өрх	өрх	8 220	8 571	8 946	375	104.4
Малчдын тоо	хүн	15 006	15 435	15 901	466	103.0
Малын тоо, бүгд	мянган.тол	3 893.6	4 202.9	4 644.8	441.9	110.5
Хувийн малын тоо, бүгд	мянган.тол	3 867.4	4 176.6	4 619.4	442.8	110.6
Хээлтэгч, бүгд	мянган.тол	1 744.3	1 871.0	2 063.7	192.7	110.3
Бойжуулсан төл, бүгд	мянган.тол	1 399.1	1 420.2	1 552.6	132.4	109.3
Том малын зүй бусын хорогдол, бүгд	тол	49 153	43 430	15 803	-27 627	36.4
Үүнээс: Өвчнөөр хорогдсон мал	тол	140	135	242	107	179.3
Тариалсан талбай						
Үүнээс: Үр тариа	га	2 010.0	5 659.0	4 099.0	-1 560.0	72.4
Төмс	га	68.9	84.8	75.7	- 9.1	89.3
Хүнсний ногоо	га	46.3	51.4	50.1	- 1.3	97.5
Хураасан ургац						
Үүнээс: Үр тариа	тн	2 173.0	4 897.9	3 478.0	-1 419.9	71.0
Төмс	тн	569.8	802.0	585.9	- 216.1	73.1
Хүнсний ногоо	тн	320.3	378.3	872.2	493.9	230.6
Бэлтгэсэн өвс	тн	15 444.1	21 985.8	18 117.8	-3 868.0	82.4
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	тэрбум.төг	46.0	57.0	51.3	- 5.7	90.0
- Борлуулсан бүтээгдэхүүн	тэрбум.төг	181.9	228.1	352.1	124.0	154.4
Тээврийн орлого	тэрбум.төг	7.4	9.6	10.9	1.3	113.5
Тээсэн ачаа	мян.тн	141.8	188.8	166.4	- 22.4	88.1
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	45.9	4.4	16.1	11.7	3.6 ¹



I.1.1. ОРШИН СУУГАА ХҮН АМЫН ТОО, сумаар, насны бүлгээр (урьдчилсан дүн)

Сум	НАСНЫ БҮЛЭГ												Хүн ам		
	0-14			15-34			35-59			60 +					
	Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:	
		Эр	Эм		Эр	Эм		Эр	Эм		Эр	Эм		Эр	Эм
Ас	582	295	287	565	298	267	638	331	307	166	68	98	1 952	992	960
Бд	1 555	765	790	1 567	813	754	1 588	800	788	392	140	252	5 102	2 518	2 584
Да	960	489	471	980	508	472	1 057	530	527	247	96	151	3 244	1 623	1 621
Мх	1 570	812	758	1 523	798	725	1 578	820	758	363	140	223	5 034	2 570	2 464
На	518	246	272	457	254	203	575	294	281	149	57	92	1 699	851	848
Он	1 163	608	555	1 079	564	515	1 208	598	610	301	118	183	3 751	1 888	1 863
Сү	1 072	577	495	1 079	620	459	1 150	615	535	235	93	142	3 536	1 905	1 631
Тш	1 129	603	526	1 030	559	471	1 068	552	516	233	88	145	3 460	1 802	1 658
Тц	741	365	376	759	401	358	806	406	400	258	110	148	2 564	1 282	1 282
Уб	844	446	398	810	452	358	952	502	450	263	104	159	2 869	1 504	1 365
Ха	513	255	258	484	265	219	603	331	272	154	65	89	1 754	916	838
Эц	2 213	1 095	1 118	2 195	1 175	1 020	2 107	1 109	998	464	187	277	6 979	3 566	3 413
Бу	8 623	4 357	4 266	6 429	3 107	3 322	6 789	3 278	3 511	2 128	849	1 279	23 969	11 591	12 378
Дүн	21 483	10 913	10 570	18 957	9 814	9 143	20 119	10 166	9 953	5 353	2 115	3 238	65 912	33 008	32 904

хүснэгт I.1.1-ийн үргэлжлэл

Сум	Хүн амаас		Өрх			Бүх хүн амд эзлэх хувь							Хүн ам зүйн ачаалал
	Аймаг, сумын төвд	Хөдөөд	Бүгд	үүнээс:		Эм	0-14	15-34	35-59	60+	Аймаг, сумын төвд	Хөдөөд	
				Аймаг, сумын төвд	Хөдөөд								
Ас	636	1 315	600	209	391	49.2	29.8	28.9	32.7	8.5	32.6	67.4	52.5
Бд	919	4 183	1 419	260	1 159	50.6	30.5	30.7	31.1	7.7	18.0	82.0	53.5
Да	1 167	2 077	957	355	602	50.0	29.6	30.2	32.6	7.6	36.0	64.0	52.5
Мх	1 333	3 701	1 493	398	1 095	48.9	31.2	30.3	31.3	7.2	26.5	73.5	54.9
На	430	1 269	492	132	360	49.9	30.5	26.9	33.8	8.8	25.3	74.7	52.5
Он	1 671	2 080	1 011	464	547	49.7	31.0	28.8	32.2	8.0	44.5	55.5	52.5
Сү	704	2 832	1 176	215	961	46.1	30.3	30.5	32.5	6.6	19.9	80.1	52.5
Тш	759	2 701	1 004	218	786	47.9	32.6	29.8	30.9	6.7	21.9	78.1	52.5
Тц	1 055	1 509	761	324	437	50.0	28.9	29.6	31.4	10.1	41.1	58.9	52.5
Уб	793	2 076	892	254	638	47.6	29.4	28.2	33.2	9.2	27.6	72.4	52.5
Ха	713	1 041	555	209	346	47.8	29.2	27.6	34.4	8.8	40.6	59.4	52.5
Эц	1 925	5 054	2 011	580	1 431	48.9	31.7	31.5	30.2	6.6	27.6	72.4	52.5
Бу	20 736	3 233	6 778	5 866	912	51.6	36.0	26.8	28.3	8.9	86.5	13.5	70.3
Дүн	32 841	33 071	19 149	9 484	9 665	49.9	32.6	28.8	30.5	8.1	49.8	50.2	60.0



I.1.2 ӨРХ, ХҮН АМЫН ТОО, багуудаар (урьдчилсан дүн)

Сум	Багийн			Өрхийн тоо	Хүн амын тоо		
	Д/д	Нэр			Бүгд	Эр	Эм
1	2	3	4	5	6	7	8
Асгат	1	1	Өлзийт	113	371	192	179
	2	2	Дөхөм	138	498	262	236
	3	3	Их-Уул	140	445	240	205
	4	4	Жаргалант	209	637	298	339
			Сумын дүн	600	1 951	992	959
Баяндэлгэр	5	1	Баян	234	859	435	424
	6	2	Дэлгэр	219	809	401	408
	7	3	Төв	194	683	329	354
	8	4	Дөхөм	269	981	486	495
	9	5	Хонгор	243	850	428	422
	10	6	Ширээт	260	920	439	481
		Сумын дүн	1 419	5 102	2 518	2 584	
Дарьганга	11	1	Үүд	189	658	338	320
	12	2	Бадрах	249	854	433	421
	13	3	Аман-Ус	164	564	285	279
	14	4	Овоот	355	1168	567	601
			Сумын дүн	957	3 244	1 623	1 621
Мөнххаан	15	1	Баянтэрэм	294	1032	542	490
	16	2	Баян-уул	292	1000	502	498
	17	3	Баянцагаан	308	972	531	441
	18	4	Баясгалант	398	1335	642	693
	19	5	Бүрэнцогт	201	695	353	342
			Сумын дүн	1 493	5 034	2 570	2 464
Наран	20	1	Гүн худаг	153	536	281	255
	21	2	Тосонгийн гол	207	733	370	363
	22	3	Наран булаг	132	430	200	230
			Сумын дүн	492	1 699	851	848
Онгон	23	1	Ихбулаг	261	1045	530	515
	24	2	Шарбүрд	175	622	316	306
	25	3	Нүдэн	257	981	492	489
	26	4	Цөнгөрөг	111	413	217	196
	27	5	Хавирга	207	690	333	357
			Сумын дүн	1 011	3 751	1 888	1 863
Сүхбаатар	28	1	Баянгол	270	756	413	343
	29	2	Хайлаастай	205	704	345	359
	30	3	Хулгар	181	1100	583	517
	31	4	Ланз	215	513	289	224
	32	5	Шинэбулаг	305	463	275	188
			Сумын дүн	1 176	3 536	1 905	1 631



хүснэгт I.1.2-ын үргэлжлэл							
1	2	3	4	5	6	7	8
Түвшинширээ	33	1 Сэргэлэн		218	759	380	379
	34	2 Өлзийт		212	753	397	356
	35	3 Үнэгд		174	624	332	292
	36	4 Дэлгэрхаан		146	426	223	203
	37	5 Өгөөмөр		254	898	470	428
		Сумын дүн		1 004	3 460	1 802	1 658
Түмэнцогт	38	1 Лхүмбэ		242	826	425	401
	39	2 Баянцагаан		195	683	346	337
	40	3 Баян-Овоо		159	516	246	270
	41	4 Баянцогт		165	539	265	274
		Сумын дүн		761	2 564	1 282	1 282
Уулбаян	42	1 Баян		254	886	446	440
	43	2 Жаргалант		254	793	402	391
	44	3 Тэгш		182	575	312	263
	45	4 Жавхлант		91	253	141	112
	46	5 Дэлгэр		111	342	183	159
		Сумын дүн		892	2 849	1 484	1 365
Халзан	47	1 Халзан шанд		133	459	249	210
	48	2 Сахиулын шанд		93	248	132	116
	49	3 Сайншанд		120	329	175	154
	50	4 Хатавч		209	718	360	358
		Сумын дүн		555	1 754	916	838
Эрдэнэцагаан	51	1 Хөндлөн хайлааст		306	1 122	583	539
	52	2 Цагаан овоо		324	1 089	558	531
	53	3 Бадрах		214	763	399	364
	54	4 Хонгор		185	694	348	346
	55	5 Билүүт		241	889	439	450
	56	6 Жаргалант		234	752	382	370
	57	7 Хадын булан		251	832	428	404
	58	8 Алтан овоо		256	838	429	409
		Сумын дүн		2 011	6 979	3 566	3 413
Баруун-Урт	59	1 1-р баг		1 140	3 977	1 890	2 087
	60	2 2-р баг		531	1 974	944	1030
	61	3 3-р баг		500	1 732	822	910
	62	4 4-р баг		732	2 495	1 194	1 301
	63	5 5-р баг		907	3 221	1 565	1 656
	64	6 6-р баг		594	1 953	924	1029
	65	7 7-р баг		929	3 288	1 558	1 730
	66	8 8-р баг		912	3 317	1 704	1 613
	67	9 9-р баг		533	2 012	990	1022
		Сумын дүн		6 778	23 969	11 591	12 378
Аймгийн дүн				19 149	65 912	33 008	32 904



I.1.3 ХҮН АМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛ, сумаар

Сум	Төрсөн хүүхэд		Нас барсан хүн		Гэрлэлт		Цуцлалт		Шилжиж ирсэн хүн	
	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
Асгат	31	21	12	7	11	1	2	-	13	8
Баяндэлгэр	88	51	25	14	37	14	-	1	50	11
Дарьганга	75	58	19	18	24	5	1	-	15	5
Мөнххаан	104	80	18	32	24	9	1	3	50	24
Наран	39	16	10	12	10	3	2	1	14	5
Онгон	53	61	22	17	22	18	4	2	15	9
Сүхбаатар	90	65	22	17	27	22	1	1	32	18
Түвшинширээ	72	60	14	17	10	8	-	1	16	18
Түмэнцогт	41	43	13	9	12	6	-	1	28	10
Уулбаян	51	28	20	12	9	3	-	1	9	19
Халзан	21	19	8	6	8	1	-	-	2	3
Эрдэнэцагаан	141	136	40	28	39	39	5	1	24	38
Баруун-Урт	679	641	158	128	125	108	16	32	225	182
Дүн	1 485	1 279	381	317	358	237	32	44	493	350

Тайлбар: Улсын бүртгэлийн хэлтсийн 2022.12.25-ны өдрийн мэдээ

I.1.4 БҮТЭН ӨНЧИН ХҮҮХЭД, байршил, насны бүлгээр

Сум	2021	2022	Байршил			Насны бүлэг			
			Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	0-4	5-9	10-14	15+
Асгат	1	1	1	-	-	-	1	-	-
Баяндэлгэр	-	2	-	2	-	-	-	2	-
Дарьганга	1	1	-	1	-	-	-	-	1
Мөнххаан	2	1	-	-	1	-	-	-	1
Наран	-	-	-	-	-	-	-	-	-
Онгон	3	3	3	-	-	-	-	2	1
Сүхбаатар	-	2	-	2	-	-	-	1	1
Түвшинширээ	-	1	-	1	-	-	-	-	1
Түмэнцогт	1	2	-	1	1	-	-	1	1
Уулбаян	2	3	-	3	-	1	1	1	-
Халзан	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	6	5	-	5	-	-	1	3	1
Баруун-Урт	7	9	8	-	1	-	2	4	3
Дүн	23	30	12	15	3	1	5	14	10



I.1.5 ХАГАС ӨНЧИН ХҮҮХЭД, байршил, насны бүлгээр

Сум	2021	2022	Байршил			Насны бүлэг			
			Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	0-4	5-9	10-14	15+
Асгат	44	48	-	38	10	7	14	21	6
Баяндэлгэр	69	68	1	52	15	3	17	30	18
Дарьганга	36	39	-	28	11	2	7	19	11
Мөнххаан	53	62	-	36	26	6	15	21	20
Наран	14	17	-	11	6	1	3	9	4
Онгон	39	46	2	40	4	3	10	21	12
Сүхбаатар	44	49	-	32	17	7	15	24	3
Түвшинширээ	31	29	1	22	6	2	12	9	6
Түмэнцогт	29	29	-	24	5	1	6	12	10
Уулбаян	18	15	9	6	-	-	2	6	7
Халзан	11	7	-	3	4	-	1	4	2
Эрдэнэцагаан	131	119	6	90	23	8	24	51	36
Баруун-Урт	182	192	187	1	4	19	52	72	49
Дүн	701	720	206	383	131	59	178	299	184

I.1.6 ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ /ЭЦЭГ/, байршил, ам бүлийн тоогоор

Сум	2021		2022		Байршил			Насны бүлэг		
	Бүгд	Эм	Бүгд	Эм	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	3 хүртэлх	3-5	6, түүнээс дээш
Ас	145	94	110	95	6	75	29	96	12	2
Бд	219	177	219	175	6	150	63	146	58	15
Да	142	116	153	126	-	126	27	134	18	1
Мх	174	163	183	159	4	125	54	60	108	15
На	68	51	67	53	5	43	19	59	5	3
Он	149	111	141	107	17	101	23	111	25	5
Сб	136	103	121	92	-	60	61	102	18	1
Тш	148	125	136	113	4	86	46	83	49	4
Тц	187	148	217	178	-	156	61	145	65	7
Уб	134	109	126	104	11	67	48	93	30	3
Ха	65	47	69	50	7	23	39	62	5	2
Эц	365	300	370	303	24	256	90	244	106	20
Бу	843	714	811	684	749	2	60	478	289	44
Дүн	2 775	2 258	2 723	2 239	833	1 270	620	1 813	788	122

**I.1.7 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр**

Сум	2021	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо			Хөгжлийн бэрхшээлийн төрөл							Төрөлхийн	Олдмол	Байршил		
		Бүгд	Эмэгтэй	Хөдөлмөр эрхэлдэг	Хараа	Хөдөлгөөн	Хавсарсан	Яриа	Сэтгэгц	Сонсгол	Бусад			Нийслэл, аймгийн төв	Сумын төв	Хөдөө
Ас	77	73	28	42	11	10	1	4	15	8	24	23	50	2	25	46
Бд	220	206	87	6	32	34	-	6	45	24	65	84	122	6	94	106
Да	122	122	43	72	22	14	-	3	31	10	42	35	87	-	58	64
Мх	147	181	63	64	21	39	7	8	38	11	57	61	120	-	99	82
На	74	78	24	-	11	17	1	5	16	6	22	28	50	-	35	43
Он	171	147	54	59	31	15	14	2	32	18	35	48	99	-	79	68
Сб	120	128	54	61	21	25	4	4	20	6	48	45	83	-	49	79
Тш	153	171	68	62	17	30	6	3	28	18	69	63	108	3	92	76
Тц	90	83	19	11	10	29	1	4	18	3	18	29	54	2	51	30
Уб	110	118	37	42	15	22	4	4	43	5	25	41	77	9	49	60
Ха	76	98	36	41	15	24	1	5	14	4	35	27	71	11	39	48
Эц	266	295	125	41	37	101	4	7	52	17	77	90	205	7	145	143
Бу	1 081	1 381	634	428	192	256	56	28	196	117	536	468	913	1 180	2	199
Дүн	2 707	3 081	1 272	929	435	616	99	83	548	247	1 053	1 042	2 039	1 220	817	1 044

I.2 ХӨДӨЛМӨР**I.2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар**

Сум	2018.XII	2019.XII	2020.XII	2021.XII	2022.XII	$\frac{2022.XII}{2021.XII} \%$
Асгат	24	15	10	8	2	25.0
Баяндэлгэр	37	36	9	51	4	7.8
Дарьганга	29	46	35	34	3	8.8
Мөнххаан	64	48	7	38	36	94.7
Наран	23	40	28	6	10	166.7
Онгон	53	16	11	37	8	21.6
Сүхбаатар	92	65	55	48	19	39.6
Түвшинширээ	72	50	57	83	72	86.7
Түмэнцогт	23	29	20	30	11	36.7
Уулбаян	34	100	32	10	10	100.0
Халзан	13	12	4	15	1	6.7
Эрдэнэцагаан	17	35	50	32	12	37.5
Баруун-Урт	166	138	144	171	175	102.3
Дүн	647	630	462	563	363	64.5



I.2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Асгат	2	-	-	1	-	1	-	-	-	-	2	-	-	-	-	-
Баяндэлгэр	4	1	-	1	-	-	3	-	-	-	-	2	1	-	-	1
Дарьганга	3	1	-	2	-	1	-	-	-	-	-	2	1	-	-	-
Мөнххаан	36	22	-	1	2	-	27	4	2	-	-	6	18	9	2	1
Наран	10	8	-	1	2	-	5	2	-	-	1	4	4	-	1	-
Онгон	8	6	-	3	-	-	5	-	-	-	3	3	2	-	-	-
Сүхбаатар	19	6	-	-	-	3	10	4	2	-	3	11	4	1	-	-
Түвшинширээ	72	32	-	13	2	6	18	26	7	-	12	24	21	13	2	-
Түмэнцогт	11	5	-	1	-	-	10	-	-	-	1	3	3	3	1	-
Уулбаян	10	5	-	4	-	1	3	-	1	1	2	5	2	1	-	-
Халзан	1	1	-	-	-	-	1	-	-	-	1	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	12	6	-	4	-	-	8	-	-	-	2	3	5	2	-	-
Баруун-Урт	175	69	-	33	3	4	110	17	3	5	37	57	52	21	8	-
Дүн	363	162	-	64	9	16	200	53	15	6	64	120	113	50	14	2

I.2.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2018.XII	2019.XII	2020.XII	2021.XII	2022.XII	$\frac{2022.XII}{2021.XII} \%$
Асгат	175	92	30	95	126	132.6
Баяндэлгэр	117	132	156	193	30	15.5
Дарьганга	123	120	55	177	136	76.8
Мөнххаан	239	137	184	96	103	107.3
Наран	153	157	118	98	137	139.8
Онгон	218	52	122	141	41	29.1
Сүхбаатар	154	162	157	122	161	132.0
Түвшинширээ	241	177	228	258	355	137.6
Түмэнцогт	199	162	137	125	64	51.2
Уулбаян	58	312	158	124	82	66.1
Халзан	120	101	41	39	33	84.6
Эрдэнэцагаан	92	169	110	103	95	92.2
Баруун-Урт	1 341	990	783	1 018	1 027	100.9
Дүн	4 157	3 230	2 279	2 589	2 390	92.3



I.2.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

Сум	2018.XII	2019.XII	2020.XII	2021.XII	2022.XII	$\frac{2022.XII}{2021.XII} \%$
Асгат	71	53	9	52	104	2.0 ¹
Баяндэлгэр	39	20	65	35	6	17.1
Дарьганга	57	19	37	30	55	183.3
Мөнххаан	98	33	51	29	29	100.0
Наран	87	84	79	52	91	175.0
Онгон	70	5	43	49	17	34.7
Сүхбаатар	41	109	110	21	56	2.7 ¹
Түвшинширээ	113	90	69	81	153	188.9
Түмэнцогт	40	30	33	43	21	48.8
Уулбаян	8	64	52	37	38	102.7
Халзан	41	32	17	10	24	2.4 ¹
Эрдэнэцагаан	22	11	9	7	11	157.1
Баруун-Урт	251	252	272	161	156	96.9
Дүн	938	802	846	607	761	125.4

I.2.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
